



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/238

Чойбалсан

Г Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогыг зохион байгуулах комисс байгуулах тухай Г

Монгол улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7."а", 20 дугаар зүйлийн 20.2, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 16 дугаар зүйл, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.г дэх заалт, Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны А/65 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүн ам, орон сууцны завсрын тооллогыг 2015 онд явуулах болсонтой холбогдуулан тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг нэгдүгээр хавсралтаар, комиссын ажиллах журам, чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар, хөдөө сумдын тооллогын комиссыг гуравдугаар, Хэрлэн сумын тооллогын комиссыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

2.Сумдын тооллогын комиссын дарга нарт дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосугай.

а/Сумын комиссын ажиллах журам, чиг үүрэг, ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах

б/Орон сууц, хашаа, гудамж, талбайн нэр, хаягийг цэгцлэх, анхан шатны иргэний бүртгэлийг бүрэн хөтлөх, иргэний бичиг баримтын зөрчлийг арилгах, хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэлтийг иж бүрэн дуусгах ажлыг онцгой ач холбогдол өгч зохион байгуулах

в/Хүн ам, өрхийн мэдээллийн сан хариуцсан ажилтнуудыг ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангах

3.Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогын аймаг, сумын тооллогын комиссыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын явцын байдалд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг тухай бүр нь авч ажиллахыг аймгийн комиссын орлогч, Статистикийн хэлтсийн дарга Д.Энхбаатарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

01 697

Аймгийн Засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 27 ны өдрийн 1/2 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ЗАВСРЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын дарга: -Аймгийн Засаг дарга
- Комиссын орлогч дарга: -Аймгийн Засаг даргын орлогч
-Статистикийн хэлтсийн дарга
- Комиссын гишүүд:
- Засаг даргын Тамгын газрын дарга
 - Хэрлэн сумын Засаг дарга
 - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хүн амын хөгжил, нийгмийн бодлогын хорооны дарга
 - Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
 - Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
 - Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга
 - Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
 - Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
 - Хөдөлмөрийн хэлтсийн дарга
 - Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга
 - Боловсрол, соёлын газрын дарга
 - Эрүүл мэндийн газрын дарга
 - Цагдаагийн газрын дарга
 - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
 - Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний Зүүн бүс дэх газрын дарга
 - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга
- Комиссын нарийн бичгийн дарга: -Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Дорнод аймгийн Засаг даргын 2015 оны
05 дугаар сарын 27-ны өдрийн 12 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГЫН
АЙМГИЙН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулж явуулах комиссын (цаашид тооллогын комисс гэх) үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын уялдаа холбоог зохицуулахад энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.2. Тооллогын комиссын зорилго нь хүн ам, орон сууцы 2015 оны завсрын тооллогын бэлтгэлийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хангах, хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэлтийг иж бүрэн дуусгах, тооллогод тодорхой үүрэгтэйгээр оролцох байгууллагуудыг ажлын уялдаа, холбоо, нэгдсэн зохицуулалтаар хангахад оршино.

1.3. Сумын тооллогын комиссын бүрэлдэхүүнд тооллого явуулахад зайлшгүй оролцож ажиллах байгууллагын төлөөллийг хамруулах зарчмыг баримтална.

Хоёр. Тооллогын комиссын эрхлэх ажлын хүрээ, үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Тооллогын комисс нь Хүн ам, орон сууцны тооллогын тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан үүрэгтэй.

2.2. Аймгийн тооллогын комисс сумын тооллогын комиссыг байгуулж ажиллуулна.

2.3. Тооллогын комисс нь улирал, сар, 7 хоногээр ажлаа төлөвлөж ажиллана.

2.4. Тооллогын комисс нь сар тутамд ажлын явцын мэдээллийг Хороонд (Улсын комисс) ирүүлж байна. Шаардлагатай асуудлаар Хорооны (Улсын комисс) хуралдаанд мэдээлэл оруулж болно.

2.5. Аймгийн тооллогын комисс сумын тооллогын комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай зохицуулалт хийнэ.

2.6. Завсрын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд орон сууц, хашаа, гудамж, талбайн нэр, хаягийг цэгцлэх, анхан шатны иргэний бүртгэлийг бүрэн хөтлөх, иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах, хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэлтийг иж бүрэн дуусгах ажлыг зохион байгуулна.

2.7. Аймагт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй иргэн, орон гэргүй хүн, албан бусаар ашигт малтмал олборлогчид болон тухайн нэгжид оршин суух бүртгэлгүй иргэдийн бүртгэлийг цэгцэлж, холбогдох мэдээллийн сангуудын мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулна.

2.8. Засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хилийг тодорхой болгох, өрхийн байршлыг тодорхойлох зорилгоор аймгийн хэмжээний кадастрын мэдээллийг ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.9. Хүн ам, орон сууцны завсрын тооллого болон хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлын зорилго, ач холбогдол, үүнд иргэдийн оролцох үүргийн талаарх сурталчилгааг хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулна.

2.10. Тооллогын комисс хүн ам, өрхийн мэдээллийн сангийн ажилтнуудад зориулсан сургалтын бэлтгэлийг хангаж, чанартай зохион байгуулах бөгөөд ҮСХ-ноос явуулах сургалтад холбогдох мэргэжлийн хүмүүсийг хугацаанд нь бүрэн хамруулж, хяналт тавина.

2.11. Хүн ам, орон сууцны завсрын тооллого явуулах батлагдсан зардлыг нэр, төрлийн дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлагатай нэмэлт зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

Гурав. Тооллогын комиссын гишүүдийн чиг, үүрэг

3.1. Тооллогын комиссын гишүүдийн чиг, үүрэг гишүүн тус бүрээр:

Тооллогын комиссын даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тооллого явуулах бэлтгэлийг хангах;
- Батлагдсан төсвийг захиран зарцуулах, зарцуулалтад хяналт тавих;
- Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийг мөрдөж ажиллах;

Тооллогын комиссын орлогч дарга, аймгийн Засаг даргын орлогчийн хариуцах ажлын чиг үүрэг:

- Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүрдэлтийг бүрэн хийх;
- Тооллогод оролцож, хамтран ажиллах байгууллагуудын ажлын уялдааг зохицуулах;
- Тооллого явуулахтай холбогдуулан харьяа нутаг дэвсгэрийн гудамж, талбайн нэр барилга, байгууламж, орон сууцны хаягжилтыг цэгцлэх;
- Хяналтын тооллогыг удирдан зохион байгуулна.
- Тооллогын комиссын даргыг түр эзгүйд орлох;

Тооллогын комиссын орлогч дарга, аймгийн Статистикийн хэлтсийн даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- Статистикийн байгууллага болон тооллогын комиссын үйл ажиллагааны уялдааг, холбоог хангах;
- Тооллогын комиссын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- Тооллогын ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулж явуулах;
- Төсвийн тооцоог нарийвчлан гаргаж, тооллогын комиссоор хэлэлцүүлэх;
- Тооллогын комиссын даргыг түр эзгүйд орлох;

Тооллогын комиссын нарийн бичгийн дарга, аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтний хариуцах ажлын чиг үүрэг:

- Тооллогын комиссын хурлын бэлтгэлийг хангаж хуралдуулах;
- Тооллогын комиссын шийдвэрийг сумын тооллогын комисст шуурхай мэдээлэх;
- Тооллогын комиссын албан хэрэг, хурлын тэмдэглэл хөтөлж, гарсан шийдвэрийг албажуулах;
- Тооллогын комиссын ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;

Тооллогын комиссын гишүүн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- Аймаг, сумын тооллогын комиссын гишүүд болон гэрээт ажилтнуудад сургалтыг хамтран зохион байгуулах, зөвлөгөө өгч ажиллана.
- Аймаг, сумын Тамгын газартай хамтран багийн ХАӨМС-д хяналт, үнэлгээ хийж, хяналт үнэлгээ хийсэн ажлын талаар танилцуулга бичиж мэдээлж ажиллах, гарсан асуудлыг шийдвэрлэнэ.
- Тооллогын үйл ажиллагааг сурталчилах, олон нийтэд танин мэдүүлэх ажлыг зохион байгуулна.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хүн амын хөгжил нийгмийн бодлогын хорооны даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- НХҮЕГ-ын ӨАТМС, Асрамжийн мэдээллийн сан (ахмад настан, хүүхэд)-г хүн ам, өрхийн мэдээллийн сантай холбоход анхаарч хамтран ажиллана.
- НДЕГ-ын Нийгмийн даатгалын сан, Эдийн засгийн идэвхтэй хүн амын сан, Өрхийн эрүүл мэндийн даатгалын санг хүн ам, өрхийн мэдээллийн сантай холбоход анхаарч хамтран ажиллана.
- Мэдээллийн сангуудын хоорондын уялдаа үр дүнгийн хүснэгтээр нягтлан шалгаж, санал дэвшүүлнэ.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- Төсвийн тооцоог нарийвчлан гаргаж, тооллогын комиссын хурлаар хэлэлцүүлж батлуулах.
- Батлагдсан төсвийг бүрэн санхүүжүүлж, хэрэгжилтэнд хяналт тавих

Тооллогын комиссын гишүүн аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- Сумдын нийгмийн ажилтнуудыг хүн ам, өрхийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, арга зүйгээр хангана.
- НХҮЕГ-ын ӨАТМС, Асрамжийн мэдээллийн сан (ахмад настан, хүүхэд)-г хүн ам, өрхийн мэдээллийн сантай холбоход анхаарч хамтран ажиллана.
- НДЕГ-ын Нийгмийн даатгалын сан, Эдийн засгийн идэвхтэй хүн амын сан, Өрхийн эрүүл мэндийн даатгалын санг хүн ам, өрхийн мэдээллийн сантай холбоход анхаарч хамтран ажиллана.
- Мэдээллийн сангуудын хоорондын уялдаа үр дүнгийн хүснэгтээр нягтлан шалгаж, санал дэвшүүлнэ.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- Комиссын гишүүдэд болон тооллогын анхан шатны ажилтнуудыг мэдээллийн нууцлалыг хэрхэн ханган ажиллах талаар арга зүйгээр хангах
- Хууль эрхзүйн дагуу тооллогыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, чиглэл өгөх
- ХЗЯ-ны ИХШХЕГ-ын Гадаадад урт хугацаагаар суугаа Монгол улсын харьяат иргэдийн сан, Монгол Улсад удаан хугацаагаар суугаа гадаадын иргэдийн санг ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- БХЯ-ны Жагсаалын цэргийн сан, ХЗЯ-ны Дотоодын цэргийн сан, ХХЕГ-ын Хилийн цэргийн сан, ШШГЕГ-ын Хоригдол, сэжигтний сан, ЦЕГ-ын орон гэргүй иргэдийн санг ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Боловсрол, соёлын газрын даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- БСШУЯ-ны ЕБС мэдээллийн сан, Төрийн сан, СӨБ мэдээллийн санг ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Эрүүл мэндийн газрын даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- ЭМСЯ-ны Төрөлт, Нас баралтын санг ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- Ажил эрхлэлтийн байдал, ажилгүйдэл түүний шалтгааныг үзүүлэлтийг гаргах ажлыг нягтлан шалгаж, аргачлалаар ханган ажиллана.

Тооллогын комиссын гишүүн Хэрлэн сумын Засаг даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн иж, бүрдэлтийг хангаж, чанартай хийж, ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх
- ХАӨМС-г төрийн захиргааны болон салбарын төв байгууллагуудын холбогдох сангуудтай уялдуулж, мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрдүүлэх
- Тооллого явуулахтай холбогдуулан харьяа нутаг дэвсгэрийн гудамж, талбайн нэр барилга, байгууламж, орон сууцны хаягжилтыг цэгцлэнэ.

3.2. Тооллогын комиссын гишүүд өөрсдийн хариуцсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүх талын арга хэмжээг авч, явцыг тооллогын комиссын дарга, орлогчид танилцуулж, үр дүнг комиссын хуралд тайлагнана.

3.3. Тооллогын комиссын гишүүд хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж, өөрийн санал дүгнэлтээ бичгээр ирүүлж, хурлаас гарах шийдвэрт тусгуулна.

3.4. Тооллогын комиссын гишүүд энэхүү журам, комиссын шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврыг чанд мөрдөж, хэрэгжүүлнэ.

Дөрөв. Тооллогын комиссын хурлаар хэлэлцэх асуудал

4.1. Тооллогын комиссын гишүүдийн чиг үүргийг батлах, өөрчлөлт оруулах, сумын тооллогын комиссын мэдээллийг авч хэлэлцэн, тулгамдаж байгаа асуудлаар шийдвэр гаргах;

4.2. Тооллогын комиссын ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийн явцыг хэлэлцэх, холбогдох зохицуулалтыг хийх, шат шатанд завсрын тооллогын бэлтгэлийг хянах ажлыг зохион байгуулах, үнэлэлт, дүгнэлт өгөх;

4.3. Тооллоготой холбоотой бусад асуудал.

Тав. Хурлын дэг

5.1. Тооллогын комиссын хурлыг дарга, түүний эзгүйд орлогч дарга удирдан явуулна.

5.2. Тооллогын комиссын хурлыг гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэй үед хуралдуулах бөгөөд улирал тутам зохион байгуулна.

5.3. Асуудлыг хуралд оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хурлыг хуваарийн дагуу хийнэ.

Зургаа. Хурлын шийдвэр

6.1. Хурлаар хэлэлцсэн асуудлаар гарсан санал, дүгнэлт шийдвэрийг тэмдэглэл үйлдэж, шаардлагатай асуудлаар тооллогын комиссын даргын захирамж гаргаж баталгаажуулна.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- ГХГЗЗГ-ын Хаягийн сан, Газрын нэгдмэл сан
- Харьяа нутаг дэвсгэрийн гудамж, талбайн нэр, байр, орон сууцны хаягжилт, дугаарыг цэгцлэх ажлыг зохион байгуулах
- Малчдын өрхийн цэгийг багийн зурагт тэмдэглүүлэх
- Байшингийн дээвэр, байрны орц, хонгил, дулааны шугам сүлжээний суваг, ой мод, уул хад, агуйд амьдардаг болон албан бус аргаар ашигт малтмал олборлодог хүмүүсийг бүртгэлд бүрэн хамруулах бэлтгэл ажлыг зохион байгуулах
- Гудамж, талбайн нэр барилга, байгууламж, орон сууцны хаягжилтыг цэгцлэнэ.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Цагдаагийн газрын даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- ЦЕГ-ын Дотоодын цэрэг болон орон гэргүй иргэдийн санг ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- УБЕГ-ын Иргэний мэдээллийн сан
- УБЕГ-ын Үл хөдлөх хөрөнгийн сан
- УБЕГ-ын Хуулийн этгээдийн сан, Бизнес регистрийн сангуудыг ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.
- Анхан шатны иргэний бүртгэлийг бүрэн хөтлөх, иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах, хүн ам, өрхийн бүртгэлийг иж бүрэн болгох

Тооллогын комиссын гишүүн аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- ШШГЕГ-ын Хоригдол, сэжигтний санг ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний зүүн бүс дэх газрын даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- ХЗЯ-ны ИХШХЕГ-ын Гадаадад урт хугацаагаар суугаа Монгол улсын харьяат иргэдийн сан, Монгол Улсад удаан хугацаагаар суугаа гадаадын иргэдийн санг ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.
- Гадаадад оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн мэдээллийг тэдний регистрийн дугаарыг үндэслэн интернетээр бүртгэх ажлыг зохион байгуулна.
- Иргэдийн ХАӨМС дахь мэдээллийг баяжуулах, хяналт, мониторинг хийхэд электрон асуулга боловсруулж, таблет төхөөрөмж ашиглана.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- НДЕГ-ын Нийгмийн даатгалын сан, Эдийн засгийн идэвхтэй хүн амын сан, Өрхийн эрүүл мэндийн даатгалын санг ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.

Тооллогын комиссын гишүүн аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргын хариуцах ажлын чиг үүрэг:

- НХҮЕГ-ын ӨАТМС, Асрамжийн мэдээллийн сан (ахмад настан, хүүхэд) ХАӨМС-тай нэгтгэн холбох ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.

Аймгийн Засаг даргын 2015 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 12 дүгээр захирамжийн гуравдугаар хавсралт



ХӨДӨӨ СУМДЫН ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|----------------------------------|--|
| Тооллогын комиссын дарга: | -Сумын Засаг дарга |
| Тооллогын комиссын орлогч дарга: | -Сумын Засаг даргын орлогч |
| Гишүүд: | -Сумын Засаг даргын Тамгын газрын дарга |
| | -Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга |
| | -Сумын Санхүүгийн албаны дарга |
| | -Сумын Засаг даргын Тамгын газрын Газрын даамал |
| | -Сумын Эрүүл мэндийн төвийн дарга |
| | -Сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал |
| | -Сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч |
| | -Сумын Иргэний бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | -Сумын Татварын улсын байцаагч |
| | -Сумын Нийгмийн даатгалын байцаагч |
| | -Сумын Нийгмийн ажилтан |
| | -Багийн Засаг дарга нар |
| Нарийн бичгийн дарга: | -Сумын Төрийн сангийн мэргэжилтэн |

Дорнод аймгийн Засаг даргын 2015 оны
05 дугаар сарын 27-ны өдрийн /27/ тоот
захирамжийн дөрөвдүгээр хавсралт



ХЭРЛЭН СУМЫН ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ЗАВОРЫН ТООЛЛОГЫН
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Тооллогын комиссын дарга: -Хэрлэн сумын Засаг дарга
- Тооллогын комиссын орлогч дарга: -Хэрлэн сумын Засаг даргын орлогч
- Гишүүд:
- Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга
 - Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга
 - Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Эрүүл мэнд нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Боловсрол соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Цэрэг онцгой байдал хариуцсан мэргэжилтэн
 - Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Хэрлэн сумын Газрын даамал
 - Хэрлэн сумын Татварын улсын байцаагч
 - Хэрлэн сумын Нийгмийн даатгалын байцаагч
 - Хэрлэн сумын Нийгмийн ажилтан
 - Багийн засаг дарга нар
- Нарийн бичгийн дарга: -Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын
Статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн